



**ХЭНТИЙ АЙМГИЙН  
БАЯН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2025 оны 05 сарын 14 өдөр

Дугаар 0181

Жавхлант

**Хөрөнгө зарцуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 59 зүйлийн 59.1.23, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2, 14.2.3, Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны 12 дугаар сарын 30-ний өдрийн А/19 тоот тогтоолын 7 дугаар хавсралт 2025 оны Засаг Даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлын 2.2 дахь хэсгийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын Засаг Даргын 2025 оны үйл ажиллагааны зардлын Хамтарсан багийн төсвөөс "Гэр бүлийн өдөр" - ийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд зохион байгуулж буй үйл ажиллагаанд 300,000 (гурван зуун мянган төгрөг)-ийг зарцуулсугай.

2. Дээрх зардлыг Засаг Даргын үйл ажиллагааны "Хамтарсан баг"-ийн зардлаас санхүүжүүлэхийг нягтлан бодогч (Э.Уранбайгаль)-д үүрэг болгосугай.

3. Дараах үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (М.Шаравгаваа)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.БАТЧУЛУУН

Сумын Засаг даргын 2025 оны 05 дугаар  
сарын 14-ны өдрийн 011 тоот  
захирамжийн I хавсралт

**Залуу гэр бүлийг алдаршуулах батламж гардуулах төсөв**

| № | Үйл ажиллагаа                                     | Зардлын нэр           | Тоо<br>хэмжээ | Нэг<br>бүрийн<br>үнэ | Нийт Дүн |
|---|---------------------------------------------------|-----------------------|---------------|----------------------|----------|
| 1 | Гэр бүлийг<br>алдаршуулах<br>батламж<br>гардуулах | Гарт олгох мөнгөн дүн | 3             | 100000               | 300000   |